БАТЛАВ:
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА М.БАДАМСҮРЭН

ЧОЙБАЛСАН ХОТЫН ОДОО АШИГЛАЖ БАЙГАА ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙН ХААЛТЫН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар №ДЗД/23-05

2023.01.25 Чойбалсан хот

Зураг төсөл зохиох үндэслэл	- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.10; - Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт 20.18; - Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.9.3; - Хог хаягдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1; - Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө.
1. Барилга байгууламжийн байршил, чиглэл	Дорнод аймаг, Хэрлэн сумын 1 дүгээр баг, одоо ашиглаж байгаа хогийн цэг
2. Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль - Хот байгуулалтын тухай хууль - Газрын тухай хууль - Хог хаягдлын тухай хууль - Барилгын тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль - Бусад холбогдох хууль тогтоомжууд <u>Төсөл, хөтөлбөрүүд:</u> - Чойбалсан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө. - Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр /ЗГ-ийн 2014 оны 298 тогтоол/ - “Цэмцгэр Чойбалсан” дэд хөтөлбөр <u>Норм, нормативууд:</u> - Барилгын зураг. Угсралтын зураг ба түүнийг боловсруулах үндсэн журам MNS ISO 7519:2000 - Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт БНбД 30-01-04
3. Зориулалт, хүчин чадал	Одоо ашиглаж байгаа хогийн цэг нь нөөц талбайгүй болсон, хөгжлийн ерөнхий

	төлөвлөгөөнд суурьшлын бүсээр төлөвлөгдсөн. /Нийт талбай 40 га/
4. Хэрэглэгчийн ачаалал	Чойбалсан хотын хог хаягдал өдөрт 200-250 тн
5. Зураг төслийн бүрэлдэхүүн	- Ажлын зургийг гүйцэтгэхдээ "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөл оруулах" журмыг баримтлана. - Батлагдсан ажлын даалгаварт тусгагдсан иж бүрэн ажлын зураг төслийн эх хувь, тайлбар бичгийн хамт хэвлэмэл болон тоон байдлаар CD-нд 1 хувь үйлдэж Дорнод аймгийн архив, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Засаг даргын тамгын газарт тус бүр хүлээлгэн өгөх. - Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, инженерийн шугам сүлжээний хангагч, ашиглалч байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.
6.Архитектур төлөвлөлтөнд тавигдах шаардлага	- Хучилтын хөрс эрүүл байх - Хөрс гулгахгүй, нурахгүй, шороо хийсэхгүй байх, бохир хөрс ил гарахгүй байх. - Булшилсан хог хаягдалд хими, физикийн өөрчлөлт орж, хөрс цөмрөх, нүх гарах, хөрс, гадаргуу өөрчлөгдөхгүй байх - Хөрсийг бүрэн зүлэгжүүлж, шаардлагатай газар мод тарих, тохижуулах. - Үер, усны аюулаас бүрэн хамгаалж, хаалт хашлага, далан шуудуу татах. - Хог хаягдлаас үүсэх хийг аюулгүй аргаар зайлуулах нөхцөлийг бүрдүүлэх.
7.Үйлдвэрлэл үйлчилгээний зам тээвэр	Байхгүй
8. Зургийн үе шат, хугацаа	- Бодит байдлын талаарх судалгааг хийх - Захиалагч талын төлөөлөлтэй зөвшилцөж эскиз буюу эх загвар зураг гаргах. - Хангагч талын гаргаж өгсөн техникийн нөхцөлүүд, холбогдох БНбД-үүдэд заасны дагуу ажлын зураг, төслийг боловсруулах. - Зураг төслийн дагуу барилга, угсралтын ажилд шаардагдах төсвийг гаргах. - Барилга, угсралтын ажлын явцад зохиогчийн хяналт гүйцэтгэх. - Зураг төсөл: 1 үе шаттай - Хугацаа: Гэрээнд заагдсан хоног хугацаа
9. Зураг төслийн байгууллага	Барилга архитектур, барилгын бүтээцийн зураг төсөл зохиох эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага байна.
10. Хөрөнгө оруулагч	Дорнод аймгийн Засаг дарга

(захиалагч) байгууллага	
11. Галын аюулгүй байдлын нөхцөл	Галын аюулгүй байдлын норм дүрэм, стандартын дагуу зураг төслийг боловсруулах.
12.Байгаль орчны үнэлгээ, нөхцөл	-
13. Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	- Барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. - Зураг төсөл боловсруулах явцад ашиглагч, захиалагч байгууллагатай зөвшилцөх. - Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
14. Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.

ТАНИЛЦСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА М.НЯМСҮРЭН

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА А.ГАНТУЛГА

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР А.ТҮМЭНЖАРГАЛ

БАЙГАЛЬ ОРЧИН 2110278207 9031871 ГАЗАР ТБАГУТУГ

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН С.УРАНТОГОС